

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ӨМЧЛӨХ ЭРХ,
ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭ**

_____ он _____ сар _____ өдөр

№ _____

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн ... дугаартай үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх, түүнтэй холбоотой эрхийн барьцааны энэхүү гэрээ (цаашид “**Гэрээ**” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 13 дугаар бүлэг, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг үндэслэн нэг талаас хаягт орших, түүнийг төлөөлж (цаашид “**Барьцаалагч**” гэх), нөгөө талаас “Мөнх замбала корпораци” ХХК түүнийг төлөөлж захирал Д.Уранцэцэг (цаашид “**Барьцаалуулагч**”, Барьцаалагч болон Барьцаалуулагчийг хамтад нь “**Талууд**” гэх) нар өөрсдийн хүсэл зоригийн үндсэн дээр харилцан тохиролцож дараах нөхцлөөр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Барьцаалагч болон Барьцаалуулагч нарын хооронд байгуулсан _____ он _____ сар _____ өдөр _____ тоот _____ Япон улсад ажиллаж, туршлага судлах сургалтын гэрээ, (цаашид “**Гэрээ**” гэх)- ний үүргийн биелэлтийг хангахтай холбогдуулан барьцаалах үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг тогтоох, тэдгээрийн үнэлгээ, чанарыг тодорхойлох, барьцааны гэрээ хэрэгжих үндэслэл бүрдсэн нөхцөлд Талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлоход оршино.

ХОЁР. БАРЬЦААНЫ ЗҮЙЛ

2.1. Гэрээний барьцаанд Барьцаалуулагч нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор дараах үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйл, орлого, үр шим, үл хөдлөх эд хөрөнгийг засан сайжруулсан хөрөнгө, нэмэлт хөрөнгө оруулалт (цаашид хамтад нь “барьцааны зүйл” гэх)-ыг барьцаалсан болно. Үүнд:

.....

2.2. **Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, түүнийг тодорхойлох:** Гэрээний 2.1- д заасан барьцаагаар хангагдах үүргийн үнийн дүнгээс гадна барьцаагаар хангагдах шаардлагад гэрээ, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх шүүхийн зардал, барьцааны зүйлийг арчлан хамгаалах, засан сайжруулахад гарсан зардал, уг үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар, хураамж, төлбөр, шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлсөн урамшуулал, зардал болон барьцаалагчид учирсан хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

2.3. **Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа:** Барьцаагаар хангагдах үүрэг нь барьцаалагч болон барьцаалуулагч нарын хооронд байгуулсан _____ он _____ сар _____ өдрийн _____ тоот _____ Япон улсад ажиллаж туршлага судлах сургалтын гэрээнд заасны дагуу тодорхойлогдох болно. Барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа, түүнтэй холбоотой бусад нөхцлийг гэрээнд заасны дагуу тодорхойлно.

2.4. **Төлбөр гүйцэтгэх хугацаа, давтамж, хэмжээ, түүнийг тодорхойлох:** Япон улсад ажиллаж туршлага судлах сургалтын гэрээнд заасан хугацааны дагуу тодорхойлогдоно.

2.5. Барьцааны эрх нь барьцаалбараар гэрчлэгдэхгүй.

2.6. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх барьцаалсан тохиолдолд тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа: _____

Үргэлжлэл бий